



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/07

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.4, 4.1, аймгийн Онцгой комиссын 2023 оны 01, Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 10 суманд мал аж ахуйн салбарын өвөлжилт эрсдэлтэй түвшинд байгаатай холбогдуулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын өвөлжилт хүндэрч байгаа аймаг сумдын малчин өрхүүдэд чиглэсэн "Хамтдаа давья" аянд нэгдэж 6,000,000 (Зургаан сая) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх зардлын 6,000,000 (Зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6711011230